



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 472

Улаанбаатар хот

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв”
төрийн өмчит үйлдвэрийн газрын
2019 оны төлөвлөгөөг шинэчлэн
батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдаж, гадаад болон дотоод төсөл хөтөлбөр, судалгааны ажлууд тодорхой хугацаагаар хойшлогдсонтой холбогдуулан “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг шинэчилсэнтэй холбогдуулан 2019 оны бизнес төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг захирал Ц.Цэрэнд үүрэг болгосугай.

3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 644 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000975

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн
472 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
2019 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 оны гүйцэтгэл	2019 оны төлөвлөгөө	2019 оны шинэчилсэн төлөвлөгөө	Харьцуулалт	
						2019 оны шинэ төл/2019 оны төлөвлөгөө	Зөрүү (2019 шинэ төл-2019 оны төлөвлөгөө)
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
	а/ Гол нэр төрлөөр	мян.төг	-	-	-	-	-
	б/ Үнийн дүнгээр	мян.төг	1,604,960.9	1,607,391.5	997,000.0	62.0	(610,391.5)
	Нийт орлого	мян.төг	1,604,960.9	1,607,391.5	997,000.0	62.0	(610,391.5)
2	Үүнээс: Цэвэр борлуулалтын орлого	мян.төг	1,592,220.4	1,600,195.5	989,804.0	61.9	(610,391.5)
	Түрээсийн орлого	мян.төг	5,269.1	7,196.0	7,196.0	100.0	-
3	Нийт зардал	мян.төг	1,086,595.5	1,519,242.8	993,454.0	65.4	(525,788.8)
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	78,265.4	82,957.0	69,961.3	84.3	(12,995.7)
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	518,365.3	88,148.7	3,546.0	4.0	(84,602.7)
5	Цэвэр ашиг/алдагдал/	мян.төг	466,528.8	79,333.8	3,191.4	4.0	(76,142.4)
6	Ногдол ашиг	мян.төг	37,172.9	34,349.7	10,000.0	29.1	(24,349.7)
7	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төг	0.7	0.9	1.0	105.4	0.1
8	Хөрөнгө оруулалт	мян.төг	397,609.4	247,093.3	232,145.0	94.0	(14,948.3)
	Нийт авлага	мян.төг	84,003.70	67,583.1	74,980.0	110.9	7,396.9
9	Үүнээс: 0-5 жилийн насжилттай	мян.төг	59,221.5	45,959.7	46,399.7	101.0	440.0
	5-10 жилийн насжилттай	мян.төг	22,292.1	21,623.4	28,580.3	132.2	6,956.9
10	Нийт өглөг	мян.төг	130,193.9	40,000.0	117,174.5	292.9	77,174.5
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	130,193.9	40,000.0	117,174.5	292.9	77,174.5
11	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	-	-	-	-	-
	Нийт ажиллагсдын тоо	хүн	39	39	39	100.0	-
12	Нийт цалингийн сан	мян.төг	364,900.8	474,450.0	381,118.7	80.3	(93,331.3)
13	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	950.3	1,013.8	1,058.7	104.4	44.9

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 11 дүгээр сарын 19 -ны өдрийн
472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ"
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	тоо, ширхэг	Нэгжийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
Нэг. Их засвараар хийгдэх ажил				
1	Сэргээгдэх эрчим хүчийг сурталчилан таниулах судалгааны төв, үзүүлэн бэлтгэх	1	55,000,000.0	55,000,000.0
	Дүн			55,000,000.0
Хоёр. Хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил				
1	Тоног төхөөрөмж	1	170,000,000.0	170,000,000.0
2	Тооцооллын программ PV system, Meteonorm, Pvsol, Wind pro	2	2,741,000.0	5,482,000.0
3	GPS - GeoNet GPS	1	413,000.0	413,000.0
4	Архивын тавиур	2	625,000.0	1,250,000.0
	Дүн			177,145,000.0
	НИЙТ ДҮН			232,145,000.0